IMK
CPAs & REGISTERED AUDITORS

# АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**“ЭРДЭНЭТСУВРАГА” ХК**
(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

**2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр**
**Тасалбар болгосон санхүүгийн тайлан**

**Улаанбаатар хот**
**2026 он**

## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| ЗАХИРАЛ: | Н.ОДОНБИЛЭГ |
| АЛБАН ХАЯГ: | Булган, Булган, 1-р баг, Ачуут, шинэ хороо, Зам ангийн байр-1<br><br>Утас: +976 9901-3560 |
| АУДИТЫН КОМПАНИ: | ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК<br><br>Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Төмөрчний гудамж, 8 дугаар байр, 1003 тоот<br><br>Утас: +976 7000-1778<br>Факс: +976 7000-1778<br>И-мэйл: /www.imkaudit.mn/ |

IHMONGOL KHULUG AUDIT Co.,Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Захирал Н.Одонбилэг, ерөнхий нягтлан бодогч Б.Батчимэг бид манай аж ахуйн нэгжийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй.
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан.
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

| | |
|---|---|
| **"ЭРДЭНЭТСУВРАГА" ХК** | **"ЭРДЭНЭТСУВРАГА" ХК** |
| /Байгууллагын нэр/ | /Байгууллагын нэр/ |
| ЗАХИРАЛ | НЯГТЛАН БОДОГЧ |
| /Албан тушаал/ | /Албан тушаал/ |
| Н.ОДОНБИЛЭГ | Б.БАТЧИМЭГ |
| /Овог нэр/ | /Овог нэр/ |
| ............................................ | ............................................ |
| /Гарын үсэг, тамга/ | /Гарын үсэг, тамга/ |
| ............................................ | ............................................ |
| /Огноо/ | /Огноо/ |


IKHMONGOL KHULUG AUDIT Co.,Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

"ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ" ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Жамьянжавын гудамж, Рааш булаг төв, 404 тоот
Утас: (+976) 7000 – 1778, И-мэйл: info@imkaudit.mn

2026.03.06 № Ø/2026/09

Танай_____________-ны №_________________-т

"ЭРДЭНЭТСУВРАГА" ХХК-ИЙН УДИРДЛАГАД

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Бид "Эрдэнэтсуврага" ХХК (цаашид "Компани"гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

## Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

## Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг.

Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

**Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

**Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцэж байна.

**ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК**

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2026 оны 03 дугаар сарын 06

УЛААНБААТАР ХОТ
ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК
ТТБ6584 р/д 3856399

С.ТУНГАЛАГ

Захирал

# “ЭРДЭНЭТСУВРАГА” ХК
# АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2024.12.31. | 2025.12.31. |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 865,338,527.04 | 1,924,331,355.84 |
| Дансны авлага | 683,370,280.72 | 505,221,257.22 |
| Татвар, НДШ-ийн авлага | - | 0.80 |
| Бусад авлага | 1,500,000.00 | - |
| Бараа материал | 10,063,968.20 | 781,428,894.97 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 27,690,851.13 | 281,402,204.13 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,587,963,627.09** | **3,492,383,712.96** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 2,198,153,256.19 | 3,051,546,148.91 |
| Биет бус хөрөнгө | 4,234,590.29 | 5,789,666.67 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,202,387,846.48** | **3,057,335,815.58** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,790,351,473.57** | **6,549,719,528.54** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| Татварын өр | 381,757,019.47 | 257,180,875.20 |
| Богино хугацаат зээл | 215,000,000.00 | 145,010,694.40 |
| Урьдчилж орсон орлого | 21,765,390.00 | 2,953,165,386.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 140,916,618.84 | 140,916,618.84 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **759,439,028.31** | **3,496,273,574.44** |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 14,091,661.88 | 14,091,661.88 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **14,091,661.88** | **14,091,661.88** |
| **Өр төлбөрийн дүн** | **773,530,690.19** | **3,510,365,236.32** |
| Өмч Хувийн | 636,598,400.00 | 636,598,400.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,168,395,800.00 | 1,168,395,800.00 |
| Хуримтлагдсан ашиг | 1,211,826,583.38 | 1,234,360,092.22 |
| **Эздийн өмчийн дүн** | **3,016,820,783.38** | **3,039,354,292.22** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **3,790,351,473.57** | **6,549,719,528.54** |

IHMONGOL KHULUG AUDIT Co., Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

# “ЭРДЭНЭТСУВРАГА” ХК
# АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2024.12.31. | 2025.12.31. |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **3,457,878,962.77** | **7,390,847,823.35** |
| Борлуулалтын өртөг | 1,556,071,626.78 | 4,504,590,180.47 |
| **Нийт ашиг/алдагдал** | **1,901,807,335.99** | **2,886,257,642.88** |
| Хүүний орлого | 3,160.69 | - |
| Бусад орлого | - | 2,808.87 |
| Борлуулалт маркетингийн зардал | 52,441,037.84 | 59,515,169.09 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,816,978,154.84 | 2,798,878,608.70 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал** | **32,391,304.00** | **27,866,673.96** |
| Орлогын албан татвар | 3,239,130.40 | 2,786,667.39 |
| **Татварын дараах ашиг/алдагдал** | **29,152,173.60** | **25,080,006.57** |


IKHMONGOL KHULUG AUDIT Co.,Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

# “ЭРДЭНЭТСУВРАГА” ХК
# АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **636,598,400.00** | **1,168,395,800.00** | **1,319,763,179.93** | **3,124,757,379.93** |
| Залруулсан үлдэгдэл | - | | 1,319,763,179.93 | **1,319,763,179.93** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 29,152,173.60 | **29,152,173.60** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | | (137,088,770.15) | **(137,088,770.15)** |
| **2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **636,598,400.00** | **1,168,395,800.00** | **1,211,826,583.38** | **3,016,820,783.38** |
| Залруулсан үлдэгдэл | **636,598,400.00** | **1,168,395,800.00** | **1,211,826,583.38** | **3,016,820,783.38** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 25,080,006.57 | 25,080,006.57 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | (2,546,497.73) | (2,546,497.73) |
| **2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **636,598,400.00** | **1,168,395,800.00** | **1,234,360,092.22** | **3,039,354,292.22** |

IKHMONGOL KHULUG AUDIT Co.,Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

# "ЭРДЭНЭТСУВРАГА" ХК
# АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2024.12.31. | 2025.12.31. |
|---|---|---|
| **Мөнгөн орлогын дүн** | **4,071,665,839.85** | **11,062,832,601.69** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 3,803,666,859.05 | 11,061,332,601.69 |
| Бусад мөнгөн орлого | 267,998,980.80 | 1,500,000.00 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **2,888,107,196.79** | **9,162,041,784.00** |
| Ажиллагчдад төлсөн | 177,484,760.00 | 186,754,048.80 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 51,601,900.00 | 53,858,328.00 |
| Бараа материал авахад төлсөн | 679,534,343.00 | 5,795,735,767.97 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 36,008,058.49 | 41,693,643.21 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 750,749,719.64 | 1,429,498,797.60 |
| Хүүний төлбөрт төлсөн | 114,105,794.37 | 184,920,194.39 |
| Татварын байгууллагад төлсөн | 37,954,938.28 | 101,213,652.82 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | 298,350.00 |
| Бусад мөнгөн зарлага | 1,040,667,683.01 | 1,368,069,001.21 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,183,558,643.06** | **1,900,790,817.69** |
| **Мөнгөн орлогын дүн** | **3,160.69** | **2,808.87** |
| Хүлээн авсан хүүний орлого | 3,160.69 | 2,808.87 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **436,392,750.00** | **949,393,222.16** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 133,745,000.00 | 947,493,222.16 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,147,750.00 | 1,900,000.00 |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 301,500,000.00 | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(436,389,589.31)** | **(949,390,413.29)** |
| **Мөнгөн орлогын дүн** | **6,946,800,000.00** | **5,432,462,000.00** |
| Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө | 6,946,800,000.00 | 5,432,462,000.00 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **6,847,324,343.50** | **5,324,869,575.60** |
| Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас төлсөн мөнгө | 6,846,583,087.00 | 5,324,089,305.60 |
| Төлсөн ногдол ашиг | 741,256.50 | 780,270.00 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **99,475,656.50** | **107,592,424.40** |
| **Валютын ханшны зөрүү** | **-** | **-** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **846,644,710.25** | **1,058,992,828.80** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **18,693,816.79** | **865,338,527.04** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **865,338,527.04** | **1,924,331,355.84** |



IKHMONGOL KHULUG AUDIT Co.,Ltd
CPAs & REGISTERED AUDITORS